



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2013 оны 1 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Шуудангийн үйлчилгээний давуу эрхийн
бүс, бүх нийтийн үйлчилгээний төрлийг
шинэчлэн тогтоох тухай

1. Шуудангийн тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсийг 1 дүгээр, бүх нийтийн үйлчилгээний төрлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус тогтоосугай.


2. Шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүс, бүх нийтийн үйлчилгээний төрлийг шинэчлэн тогтоосны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Б.Балгансүрэнд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Ерөнхий сайдын 2013 оны 24 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт



ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ЭРХИЙН БҮС

1. Давуу эрхийн бүс:

1.1. Нэгдүгээр зэрэглэлийн бүс:

Улаанбаатар хот

1.2. Хоёрдугаар зэрэглэлийн бүс:

Орхон аймаг
Дархан-Уул аймаг

1.3. Гуравдугаар зэрэглэлийн бүс:

Хэнтий аймгийн Өндөрхаан сум
Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум

2. Улс хоорондын давуу эрхийн үйлчилгээний бүс:

2.1. Улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээ

-----oOo-----

Ерөнхий сайдын 2013 оны 24 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

ШУУДАНГИЙН БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

1. Бодит хэмжээгээрээ стандартад нийцсэн дээд хязгаар нь 0-70 гр хүртэлх жинтэй, ердийн бичиг захидлыг хүлээн авч, дамжуулан хүргэх үйлчилгээ
2. Шуудангийн үндсэн сүлжээгээр дамжиж байгаа электрон маркаар баталгаажсан электрон шуудангийн үйлчилгээ

-----oOo-----